



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**СҮХБААТАРДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.СОНГОХБАЯР
ТАНАА**

2014.03.18

№

02/14 УАГ-САГ/2014/121/СТГА-743

Зөрчил арилгуулах тухай

Сүхбаатар дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн Халамжийн сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад Сүхбаатар дүүргийн Нийгмийн халамж Үйлчилгээний Хэлтсийн үндсэн хөрөнгөнд 2,275,000 төгрөгийн үнэтэй Бенз маркийн суудлын авто машин бүртгэлтэйбайгаа боловч биетээр байхгүй зөрчил илэрлээ.

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Бенз маркийн суудлын авто машиныг холбогдох журмын дагуу эзэн холбогдогчийг нь тогтоон, холбогдох газраар шийдвэрлүүлэн 2014 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Сүхбаатар дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн дарга Д.Сонгохбаяр, нягтлан бодогч Ц.Дуламжав нарт хариуцуулав.

Аудитор

Ш.Отгонбаяр

